



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 15

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 7,139,650 /долоон сая нэг зуун гучин есөн мянга зургаан зуун тавь/ төгрөгийн балансын үнэтэй, 100,000.12 /нэг зуун мянган төгрөг арван хоёр мөнгө/-ний үлдэгдэл өртөгтэй эдэлгээний хугацаа дууссан хавсралтад заасан эд хөрөнгийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж устган, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/-т даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)- д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

480219039

5

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар  
сарын 22 өдрийн 11 тогтоолын 01 хавсралт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын  
данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Принтер /1200/	12.01.11	1	75,000	75,000	75,000	-
2	Компьютер	12.01.11	1	800,000	800,000	800,000	-
3	Компьютер	11.06.20	1	538,000	538,000	538,000	-
4	Принтер /1020/	11.06.20	1	452,250	452,250	452,250	-
5	Дэлгэц	12.09.25	1	180,000	180,000	180,000	-
6	Автомат цагийн программ	14.09.30	1	500,000	500,000	399,999.88	100,000.12
7	Компьютер	06.01.01	4	723,600	2,894,400	2,894,400	-
8	Notebook	13.09.30	1	1,200,000	1,200,000	1,200,000	-
9	Ус буцалгагч	12.01.11	1	150,000	150,000	150,000	-
10	Нум сум	12.01.11	1	350,000	350,000	350,000	
Нийт дүн					7,139,650	7,039,649.88	100,000.12
					/долоон сая нэг зуун гучин есөн мянга зургаан зуун тавь/	/долоон сая гучин есөн мянга зургаан зуун дөчин есөн төгрөг наян найман мөнгө/	/нэг зуун мянган төгрөг арван хоёр мөнгө/